# МҮХАҮТ
## 7 ХОНОГИЙН ТОЙМ

2026.08.24 – 2026.08.28 | МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ | Дугаар / 26.13




## БУСАД НҮҮРЭНД



Лянининий 70 гаруй компани Улаанбаатарт бизнесийн түншлэл эрэлхийлж байна



МҮХАҮТ болон МИТА ТББ дижитал ур чадвар, кибер аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллана



"Хамтын санхүүжилтийн тухай" хуулийн төслийн хэлэлцүүлэг боллоо



Ази, Номхон далайн бүсийн хөгжил, зохистой хөдөлмөрийн сургалтад оролцов



Эрээн хотод Монгол, Хятадын худалдааг дэмжих уулзалт боллоо



ОХУ, БНХАУ, Монгол, Беларусь улсуудын түншлэлийн VII форум Эрхүүд эхэллээ



"Худалдааны тухай хууль"-ийн төслийн анхны хэлэлцүүлэг зохион байгууллаа



МҮХАҮТ болон Фукуямагийн худалдааны танхим уулзалт зохион байгууллаа



COP17: Эрчим хүчний шударга шилжилт, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг хэлэлцлээ



Монгол брэндүүд Эрээний үзэсгэлэнд амжилттай оролцож байна



Эмэгтэйчүүдийн манлайлал ба цөлжилттэй тэмцэх нь



МҮХАҮТ Мобара хотын худалдааны танхимын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа

# 7 ХОНОГИЙН ТОЙМ

## Лянининий 70 гаруй компани Улаанбаатарт бизнесийн түншлэл эрэлхийлж байна







"UG Экспо" төвд БНХАУ-ын Лянин мужийн 70 гаруй компани оролцсон үзэсгэлэн, B2B уулзалт эхэлж, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг хэлэлцэж байна.

## "Хамтын санхүүжилтийн тухай" хуулийн төслийн хэлэлцүүлэг боллоо



ЖДҮ болон гадаадын бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн шинэ эх үүсвэр нээх 5 бүлэг, 23 зүйлтэй үг хуулийн төслийн хэлэлцүүлэг өрнөв.



## Эрээн хотод Монгол, Хятадын худалдааг дэмжих уулзалт боллоо



Гарал үүслийн гэрчилгээ олгох, барааны ангилал болон чөлөөт бүсийн гаалийн зохицуулалтын талаар холбогдох албаныхан мэдээлэл өгч, оролцогчдын сонирхсон асуултад хариуллаа.

## "Худалдааны тухай хууль"-ийн төслийн анхны хэлэлцүүлэг зохион байгууллаа

Худалдааны харилцааг нэг цонхны тогтолцоонд шилжүүлэх, эрсдэлээс хамгаалах шинэ хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



## МҮХАҮТ болон МИТА ТББ дижитал ур чадвар, кибер аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллана



Бизнес эрхлэгчдэд дижитал ур чадвар олгох, "Технологийн зөвлөл" байгуулахаар МҮХАҮТ болон МИТА ТББ хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

## Ази, Номхон далайн бүсийн хөгжил, зохистой хөдөлмөрийн сургалтад оролцов



Шри Ланка улсад болсон бүсийн сургалтаар Ази, Номхон далайн орнууд худалдаа, хөрөнгө оруулалтыг тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах асуудлаар туршлага солилцов.

## Монгол брэндүүд Эрээний үзэсгэлэнд амжилттай оролцож байна







Эрээн хотын үзэсгэлэнд МҮХАҮТ-ын дэмжлэгтэйгээр үндэсний 30 орчим баялаг бүтээгч ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүнээ сурталчилж байна.



# 7 ХОНОГИЙН ТОЙМ

## МҮХАҮТ болон Фүкүямагийн худалдааны танхим уулзалт зохион байгууллаа





Япон улсын Фүкүяма хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай ЖДҮ-г дэмжих, хүний нөөц бэлтгэх чиглэлээр хамтран ажиллах боломжийг хэлэлцлээ.

## ОХУ, БНХАУ, Монгол, Беларусь улсуудын түншлэлийн VII форум Эрхүүд эхэллээ




ЕАЭХ болон Монгол Улсын Түр худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтийг хэлэлцэх уг форумд Монголын 19 аж ахуйн нэгжийн 26 төлөөлөгч оролцож байна.

ЕАЭХ болон Монгол Улсын Түр худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтийг хэлэлцэх уг форумд Монголын 19 аж ахуйн нэгжийн 26 төлөөлөгч оролцож байна.





## COP17: Эрчим хүчний шударга шилжилт, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг хэлэлцлэв



НҮБ-ын COP17-ын хүрээнд ногоон ажлын байр, залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн түншлэлийг бэхжүүлэх гурван талт хэлэлцүүлэг боллоо.

## Эмэгтэйчүүдийн манлайлал ба цөлжилттэй тэмцэх нь





UNCCD COP17 бага хурлын хүрээнд ESG стандарт болон тогтвортой санхүүжилтээр дамжуулан эмэгтэйчүүд газрын доройтлыг бууруулах үйлсэд оролцох салбар хуралдаан боллоо.




## МҮХАҮТ Мобара хотын худалдааны танхимын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа





Япон Улсын Чиба мужийн Мобара хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын төлөөлөгчид МҮХАҮТ-д зочилж, эрчим хүч, хөдөө аж ахуй, худалдааны салбарт хамтран ажиллах, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих боломжийн талаар санал солилцлоо.

